210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,205,500.00	1,973,790.00	1,231,710.00	61.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	250,000.00	250,000.00	50.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,609,100.00	6,013,470.00	-1,404,370.00	130.47
2105	Норматив зардал	849,700.00	849,700.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	849,700.00	849,700.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,401,800.00	10,051,100.00	350,700.00	96.63
210604	Урсгал засвар	10,401,800.00	10,051,100.00	350,700.00	96.63
2107	Томилолт, зочны зардал	3,985,100.00	3,958,900.00	26,200.00	99.34
210702	Дотоод албан томилолт	3,985,100.00	3,958,900.00	26,200.00	99.34
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,632,400.00	4,506,455.00	125,945.00	97.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,926,400.00	1,922,500.00	3,900.00	99.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	304,000.00	304,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	215,500.00	143,568.00	71,932.00	66.62
210804	Тээврийн хэрэгслийн татвар	404,100.00	404,092.00	8.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	110,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,149,400.00	1,099,300.00	50,100.00	95.64
210807	Газрын төлбөр	523,000.00	522,995.00	5.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,331,700.00	29,301,826.00	1,029,874.00	96.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,013,200.00	26,514,326.00	498,874.00	98.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,318,500.00	2,787,500.00	531,000.00	84.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,956,900.00	25,953,900.00	3,000.00	99.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,956,900.00	25,953,900.00	3,000.00	99.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	16,737,300.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,520,000.00	2,520,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,699,600.00	6,696,600.00	3,000.00	99.96
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	165,369,600.00	147,235,000.00	18,134,600.00	89.03
223001	Бусад хөрөнгө	165,369,600.00	147,235,000.00	18,134,600.00	89.03
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	138,303,800.00	76,075,000.00	62,228,800.00	55.01
230001	Эргэж төлөгдөх зээл	138,303,800.00	76,075,000.00	62,228,800.00	55.01
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,128,614,200.00	1,035,852,300.00	92,761,900.00	91.78
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	140,486,600.00	140,486,600.00	0.00	100.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	140,486,600.00	140,486,600.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	846,127,600.00	835,258,880.00	10,868,720.00	98.72
320001	Орон нутгийн төсвөөс	846,127,600.00	835,258,880.00	10,868,720.00	98.72
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	142,000,000.00	60,106,820.00	81,893,180.00	42.33

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	116,893,800.00	60,106,820.00	56,786,980.00	51.42
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	25,106,200.00	0.00	25,106,200.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	28,844,052.26	- 28,844,052.26	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	17,118,938.20	- 17,118,938.20	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	100.00	70.00	30.00	70.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	137,351,034.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	137,351,034.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,351,034.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,340,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,340,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,011,034.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,411,034.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,600,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	137,351,034.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137,351,034.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	137,351,034.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 56.7 сая төгрөг болж, өмнөх оноос 27.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	83.9	56.7	-27.2
Дүн	83.9	56.7	-27.2

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 56.7 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлогын 39.6 сая, ОНХС-ийн 7.4 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн 9.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 304.0 сая, эцсийн үлдэгдэл 275.4 сая төгрөг болж, 28.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	4.9	2.1	-2.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	45.8	0	-45.8
Байгууллагаас авах авлага	17.4	22.2	4.8
Хувь хүмүүсээс авах авлага	235.9	251.1	15.2
Дүн	304.0	275.4	-28.6

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 275.4 сая төгрөг болж 28.6 сая төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн 47.2 сая, Цэцэрлэгийн 14.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 60.2 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

Өлгий сумын орон нутгийн хөгжлийн сан:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй зураг төсвийн ажил 4.5 сая, “хоёр живаа харгай” хөтөлбөрийн мод 9.0 сая, нийт 14.0 сая төгрөгийн авлага тусгаагүй байсныг залруулга хийж санхүүгийн тайланд тусгуулав.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 271.3 сая, эцсийн үлдэгдэл 76.3 сая төгрөг болж, 195.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	14.4	0	-14.4
Эм боох материал	14.4	0	-14.4
Хангамжийн материал	256.9	72.3	-184.6
Бичиг хэргийн материал	16.5	0.4	-16.1
Аж ахуйн материал	155.5	29.1	-126.4
Сэлбэг хэрэгсэл	7.6	0	-7.6
Түлш, шатах тослох материал	2.6	0	-2.6
Хүнсний материал	17.6	0	-17.6
Бусад хангамжийн материал	57.1	42.8	-14.3
Мал амьтад		4.0	4.0
Дүн	271.3	76.3	-195.0

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 76.3 сая төгрөг болж 195.0 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын бараа материалыг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,636.3 сая, эцсийн үлдэгдэл 2,295.1 сая төгрөг болж, 4,341.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,521.5	2,236.4	-4,285.1
Барилга, байгууламж, орон сууц	5,541.6	1,081.3	-4,460.3
Авто-тээврийн хэрэгсэл	254.9	152.6	-102.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	539.8	145.1	-394.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	350.9	90.9	-260.0
Бусад үндсэн хөрөнгө	426.6	352.2	-74.4
Зам, гүүрний байгууламж	931.1	931.1	0
Биет бус хөрөнгө	114.9	58.7	-56.2
Программ хангамж	4.0	2.4	-1.6

Бусад биет бус хөрөнгө	113.6	58.1	55.5
Дүн	6,636.3	2,295.1	-4,341.2

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,295.1 сая төгрөг болж 4,341.2 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын үндсэн хөрөнгийг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 25.0 сая, эцсийн үлдэгдэл 20.8 сая төгрөг болж, 4.2 төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	25.0	20.8	-4.2
Өглөг	25.0	20.8	-4.2
Ажилчидтай холбогдсон өглөг	3.3	0.1	-3.2
Байгууллагад төлөх өглөг	21.7	18.9	-2.8
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	1.8	1.8
Дүн	25.0	20.8	-4.2

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 20.8 сая төгрөг болж 4.2 төгрөгөөр буурсан нь байгууллагад болон ажилчдад төлөх өглөг буурснаас шалтгаалжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,270.8 сая, эцсийн үлдэгдэл 2,682.7 сая төгрөг болж, 4,588.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,091.6	461.1	-1,630.5
Хуримтлагдсан үр дүн	2,934.1	1,602.0	-1,332.1
Өмнөх үеийн үр дүн	2,751.7	6,126.8	3,375.1
Тайлант үеийн үр дүн	182.4	-4,524.8	-4,342.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,245.0	619.5	-1,625.5
Дүн	7,270.8	2,682.7	-4,588.1

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,682.7 сая төгрөг болж 4,588.1 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 1,602.0 сая төгрөг болж 1,332.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 157.1 сая, татварын бус орлого 63.6 сая, тусламж санхүүжилтийн орлого 934.7 сая, нийт 1,155.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 430.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Өлгий сумын засаг даргын тамгын газар:

Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмад, нутгийн зөвлөлийн гишүүдэд зориулж 0.4 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 846.1 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 25.1 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 165.3 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 142.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Өлгий сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 5/02 дугаар тогтоолоор 1,217.1 сая төгрөгөөр баталж 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 7/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 88.5 сая төгрөгөөр бууруулж 1,128.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,128.6 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 846.1 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 25.1 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 140.5 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 116.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 835.2 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 140.5 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 60.1 сая төгрөгийг санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,042.8 сая төгрөгийг зарцуулж, 5.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,042.8 сая төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь зардлыг 5.4 сая төгрөгөөр хэмнэж, 17.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Өлгий сумын ИТХ-ын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 7/01 дүгээр тогтоолд зааснаар Өлгий сумын Засаг дарга тайлант онд 138.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 157.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 112.3 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 137.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 137.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/21 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 8.4 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,686.0 сая төгрөгийн 0.5 хувь буюу 8.4 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 6.7 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өлгий сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Өлгий сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 12.3 хувиар давж биелснээс аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн давсан орлогоос 25.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авсан байна.

Сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 42.2 сая төгрөгөөр давж биелсэн байна. Иймд төсвийн орлогыг бодитой төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 154 мэдээллээс хугацаандаа оруулсан 150, хугацаа хоцроож 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 6 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 14.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 14.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	1	0.4							1	0.4
	Дүн	1	0.4							1	0.4

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 14.5 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг залруулж, 17.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Өлгий сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 17.2 сая төгрөгөөр давж биелсэн байна. Тухайлбал: Хөрөнгийн орлого 1.0 сая, малд ногдуулах албан татвар 9.5 сая, хадгаламжийн хүүгийн орлого 5.3 сая, газрын төлбөрийн орлого 1.3 сая төгрөгөөр тасарч, Цалин хөлс шагнал урамшууллын орлого 27.1 сая, үйл ажиллагааны орлого 8.0 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт "Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 66.1.1 дэх заалтад "Тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах" Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 59.1.7 дахь заалтад "хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах", 59.1.19 дэх хэсэгт "Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын татварын орлогыг бодитой төлөвлөж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хангаж, нотлох баримтын хамт 2023 оны 9 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор манай байгууллагад ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	17.2							1	17.2		
Дүн	1	17.2							1	17.2		
Нийт дүн												

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

 /А.НАНЖИДМАА/

2023 оны 03 сарын 17-ны өдөр